

Q

Паспорт болон түр оршин суугчийн үнэмлэхээ заавал биедээ авч явах ёстой юу?

**A**


Та гадагш гарах үедээ паспорт болон түр оршин суугчийн үнэмлэхээ заавал биедээ авч яваарай.

Энэ нь Японы улсын хуулинд заагдсан байдаг бөгөөд эдгээр бичиг баримтаа цагдаагийн ажилтан шаардсан үед заавал шалгуулж, цагдаагийн ажилд тусална уу. Япон улсад оршин суух эрхийнхээ хүрээнд зааснаас өөр үйл ажиллагаа явуулах, визний хугацааг хэтрүүлэн суух зэрэг нь Япон улсын хуулийг зөрчсөн үйлдэл болох бөгөөд зохих ял шийтгэлтэй байдаг.

Иймд, хуулиар тогтоосон дүрэм журмыг чандлан сахиж, Япон улсад ая тухтай ажиллаж амьдрахыг хүсье.

Q

Газар хөдлөлт зэрэг байгалийн гамшгийн үед яах ёстой вэ?

**A**

Газар хөдлөлт зэрэг байгалийн гамшиг тохиолдсон үед, цагдаагийн байгууллага та бүхний амь нас, эрүүл мэндийг юуны өмнө бодолцон,

нүүлэн шилжүүлэх зааварчилгаа өгөх, яаралтай авран туслах, өндөр барилгаас авран гаргах зэрэг гамшгаас хамгаалах үйл аж иллагаануудыг явуулдаг.

Телевиз, радио зэргээр явуулж буй мэдээ мэдээлэл болон гамшгийн талаарх сэрэмжлүүлэг зэргийг анхааралтай сонсож, сандарч тэвдлүйгээр өгөгдсөн заавар зөвлөмжийг дагана. Цагдаагийн болон хот, дүүрэг, хорооны ажилтнуудаас нүүлэн шилжүүлэх тухай мэдэгдэл ирэх үед, хэдийд ч гэсэн бэлэн байхаар бэлтгэлтэй байх хэрэгтэй. Галт тэрэг зэрэг нийтийн тээврийн хэрэгслээр зорчиж байгаа үед, жолооч, ажилтнуудын заавар, удирдамжийг дагаж мөрдөнө. Газар хөдлөлтийн гамшгийн үед, гудамж талбайд эмх замбараагүй байдал үүсэхгүйн тулд, автомашин, мотоцикл унахыг хориглодог.

Тайван ба аюулгүй байдал

Q & A

- Тайван ба аюулгүй амьдралд -



Токио хотын
нийслэлийн
захиргааны
дэргэдэх

Монгол хэл



Нүүр хуудас

街とともに。人とともに。
FOR MORE COMMUNICATION
けいしちよう

Q

Хэрвээ надад асуудал үүсвэл би хаашаа ярих вэ?


**A**

Зам тээврийн маш Онцгой байдал (үйл явдал) үүссэн тохиолдолд «110» дугаараар цагдаагийн хэлтэс рүү утасдаарай.

Гал түймэр/өвчин/гэмтлийн үед гал түймрийн хэлтэс «119» рүү утасдаарай.

Q

Цагдаагийн газарт өргөдөл гомдлоо хэрхэн яаж гаргах вэ?

**A**

Та зам тээврийн осол болон гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд, цагдаагийн газрын шуурхай дуудлагын утас болох 110 дугаарт яаралтай хандана уу.

Япон хэлээр харьцах боломжгүй тохиолдолд орчуулгын төвөөр дамжуулан таны яриаг хүлээн авна. Мөн, өөрийн эд зүйлээ гэсэн болон бусдын хаяж гэсэн эд зүйл олсон бол өөрт ойр байрлах цагдаагийн газар болон эргүүлийн байрнууд ("КОВАН")-ад хандаарай.

«#9110» дугаарын цагдаагийн зөвлөгөө авах төв зөвлөгөө авахаар хаашаа хандахыг хэлж өгөх болно.

Q

Япон улсын замын хөдөлгөөний дүрэм журмын талаар ерөнхий ойлголт өгнө үү.

**A**

Японы замын хөдөлгөөний дүрмээр, явган зорчигч баруун гарын, харин унадаг дугуй болон автомашин нь зүүн гарын дүрмээр тус тус зорчих үндсэн дүрэмтэй

бөгөөд явган зорчигч давуу эрхтэй байдаг. Явган зорчигч та явган хүний замаар явж, зам хөндлөн гарахдаа явган хүний гарцаар гараарай. Унадаг дугуйн хувьд, автозамын дүрмийг үндэс болгон баримтлах бөгөөд замын зүүн захаар нэг эгнээгээр зорчино. Хэрэв дугуйгаар зорчих боломжтой гэж заасан тэмдэг тэмдэглэгээтэй болон автозамаар зорчиход аюултай үед унадаг дугуйгаар явган хүний замаар зорчиж болдог хэдий ч явган зорчигчдын хөдөлгөөнд саад болохооргүй байдлаар зорчино. Гэрэл дохио бүхий уулзварт заавал гэрэл дохиог баримтална уу.

Мөн түүнчлэн, архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ автомашин төдийгүй унадаг дугуй жолоодохыг ч хагатуу хориглодог.

Замын хөдөлгөөний дүрэм болон ёс зүйг чанд баримтлан, аюул осолгүй, тав тухтай замын хөдөлгөөн бүхий нийгмийг бий болгоход та хувь нэмрээ оруулаарай.